



БАЯНЖАРГАЛАН СУМЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
С.ЦЭРЭН-ЯНЖИН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgov@audit.gov.mn

2016.11.11

№

01/170.

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянжаргалан сумын Сургуулийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 76,276,311.8 /Далан зургаан сая хоёр зуун далан зургаан мянга гурван зуун арван нэг / төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.

1. Хүнсний материалыг цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодоогүй, хяналтгүй зарцуулж 11,095,378.80 төгрөгийн зардалд тайлагнасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад /1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг/, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ заасныг зөрчсөн байна.

2. Цалин олгоходо ажилчдын картаар олгох цалингийн жагсаалт хийгээгүй, ажилтнуудын нэрийн дансыг бичилгүйгээр 62,325,366.00 төгрөгийг шилжүүлж анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 14.3.1-т /анхан шатны баримт бүрдүүлэх/ заасныг зөрчсөн байна.

3. Ур чадварын нэмэгдлийг 2,855,567.00 төгрөгийг илүү тооцож олгосон

Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2010 оны 8 сарын 16-ны өдрийн 362/112/183 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6-д /Багш, ажилтны ур чадварыг үнэлэхдээ дараах тусгай шалгуур үзүүлэлтийг баримтлана/ заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий

аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтөлөөгүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Холбогдох стандарт, журмын дагуу хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодож зарцуулалтанд хяналт тавьж хэвших.
2. Санхүүгийн анхан шатны баримтыг үнэн, зөв бүрдүүлж баримтжуулж хэвших
3. Цалин олгоходо ажилчдын картаар олгох, цалингийн жагсаалт хийж нэрийн дансаар олгон баримтжуулж байх
4. Ур чадварын нэмэгдлийг холбогдох журмыг баримтлаж шалгуур хангасан ажилчдад олгож байх Сургуулийн дотоод журмын 6.1- дэхь заалтыг хууль холбогдох журамд нийцүүлэн боловсронгүй болгож мөрдөх ажиллах
5. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Баянжаргалан сумын Сургуулийн захирал /С.Цэрэн-Янжин/, нягтлан бодогч /О.Ууганбаатар/ нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

#### ӨГСӨН<sup>1</sup>:



ЖАЛБАА

#### ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ С.ЦЭРЭН-ЯНЖИН  
НЯГТЛАН БОДОГЧ О.УУГАНБААТАР

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтыг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулхаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.